



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 5 сарын 09 өдөр

Дугаар 186


Улаанбаатар хот

“ГЭГЭЭРЭЛ-АЧ” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дүгээр заалт, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2003 оны 57 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. “Гэгээрэл-Ач” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2003 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс тасалбар болгон татан буулгаж, тус үйлдвэрийн газрын захирал Д.Батчулууныг мөн өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. “Гэгээрэл-Ач” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулж, захирамжийн заалтыг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрэннаран/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД